05.18.

МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251, E-mail: comoor@iaac.mn, http://iaac.mn

2017.05.10 № 05/4192
таны 2017.04.24-ны № 01/78 -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
И.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

Танилцав
[signature] 2017.05.22.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай

Дундговь аймгийн Өлзийт сумын 1 дүгээр багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Бишхорлоогийн Мөнхцэцэг, 2 дугаар багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Пүрэвийн Алтанцэцэг, 3 дугаар багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Маамын Айлтгүй, 4 дүгээр багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Чулуугийн Эрхэмбаяр, 5 дугаар багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Оргодолын Ган, 6 дугаар багийн Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн Өлзийхутагийн Буд-Очир нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР [signature] Х.ХАШБААТАР

Багийн Засаг дарга нарын
Сумын Засаг даргын 2017.05.23-ны
Б/08 тоот захирамжаар
томилов.

008619